

ИЛТГЭЛИЙН БҮТЭЦ

1. Товч танилцуулга

2. Үндсэн хэсэг

- 2.1. Үндэслэл**
- 2.2. Хэрэгжүүлсэн байдал**

3. Дүгнэлт

- 3.1. Онцлог, ач холбогдол**
- 3.2. Анхаарал татсан асуудал, бэрхшээл**
- 3.3. Шийдвэрлэсэн байдал**

4. Санал

- 4.1. Бусдад хүргэх туршлага**
- 4.2. Цаашид хөгжүүлэх санаа**

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх зорилготой бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлсэн энэ түүхэн хичээлийн жилд манай сургууль;

“Хүүхэд, гэр бүл, олон нийтийн оролцоог дэмжин, зорилготой, сурах арга барил эзэмшсэн, эрүүл дадал хэвшилтэй зөв монгол хүнийг төлөвшүүлнэ”

Бага ангийн заах аргын нэгдэл;

“Ном унших дуртай, ёс уламжлалаа дээдэлдэг, зөв дадал хэвшилтэй суралцагчийг төлөвшүүлнэ” гэсэн зорилгыг тус тус дэвшүүлэн ажиллалаа.

Сургуулийн зорилгын “...сурах арга барил эзэмшсэн...”, бага ангийн заах аргын нэгдлийн “ном унших дуртай ...” суралцагчийг төлөвшүүлэхийн тулд бид “хичээлээс гадуурх үйл ажиллагаа”-гаар “Ангийн номын сан”-гаа бүтээлчээр уншиж, улирал бүр сургуулийн захиргаанд тайлан тавихаар жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж ажиллалаа.

2. ҮНДСЭН ХЭСЭГ


2.1. Үндэслэл

- Боловсролын чанарын шинэчлэлийн үзэл санаа “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” буюу хүүхэд бүрд хичээл зааж сургах гэдэг ойлголтоос хүүхэд бүрийг өөрийн гэсэн сонирхолтой, хичээл хийх чадвартай, **ном унших хүсэлтэй**, амьдралын төлөө зүтгэдэг чармайлттай болгоход нь тусалдаг систем, эцэг эхчүүд, сургууль, багш нартай хамтран ажиллах үүрэг оролцоог хөгжүүлэхийг зорьж байна.
- Засгийн газрын 2012 – 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Эрдэм боловсролтой монгол хүн” бүлгийг үндэслэн гаргасан Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын 2012.10.08-ны №А/51-р тушаал буюу “хүүхэд, залуучуудад ном унших эрмэлзэл төрүүлэх, унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх” зорилго бүхий “НОМ” хөтөлбөр;
- Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар БСШУЯ, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг хамтран хэрэгжүүлсэн хөдөөгийн боловсролыг дэмжих READ төслийн үр дүнд бий болсон “Ангийн номын сан”-гаа тасралтгүй, үр бүтээлчээр ашиглах;
- Багшийн хувьд хүүхэд нэг бүрийн оролцоонд түшиглэсэн, тэднийг тэгш хөгжих боломжоор хангасан номыг бүтээлчээр унших арга зүйгээ тасралтгүй хөгжүүлэх хувийн хэрэгцээнд тус тус үндэслэсэн.

2.2. Хэрэгжүүлсэн байдал

а. Зорилго, чиглэл

Хичээлээс гадуурх үйл ажиллагааны улирлын төлөвлөгөөгөө боловсруулахдаа улирал бүрд ямар номыг сонгох вэ? гэдэг чиглэл тогтоож, зорилго тавьсан. Үүнд;



б. Чадваржуулах үйл ажиллагаа

Бүтээлчээр уншуулахаар сонгож авсан ном нь доорх ерөнхий чадваруудыг цогцоор нь хөгжүүлэхээс гадна бусад судлагдахуунаар эзэмших тусгай чадварыг хөгжүүлэхэд ямар дэмжлэг болох вэ? гэдгийг харгалзаж үзсэн.



Жишээлбэл:



в. Тайлагнах үйл ажиллагаа

Нэгдүгээр улиралд “20 дугаар зууныг эзэлсэн” Шведийн суут үлгэрч Астрид Линдгрений “Миний хүү Мио” уран сэтгэмжийн үлгэрийг сонгож тайлангаа тавьсан.

Энэ номыг сонгосон шалтгаан нь 2007 онд “Ангийн номын сан” төсөл хэрэгжсэнээс хойш уг номыг суралцагчид сонгож уншихгүй байгаа нь ажигдагддаг байлаа. Үүнээс үүдэн;

1. Хүүхдийн нүдээр харахад тэдний сонирхлыг татах зураггүй, зузаан, үлгэр хэдий ч үргэлжилсэн үгтэй, урт хэлбэртэй.
2. Гадаад үг ихтэй /Стокхольм хот, Уппландсготан гудамж, Бу Вильхельм Ольссон буюу Боссэ – хожим Мио гол баатрын нэр/ тул хүүхэд уншихаас төвөгшөөдөг байх гэсэн дүгнэлт хийхэд хүргэсэн.



Астрид Линдгрений “Миний хүү Мио” үлгэр 12 хэсэгтэй. Хэсэг бүр нь агуулгадаа тохирсон гарчигтай.

1. Девочка стоит рядом с домом

2. Синий домик и синий стул

3. Море и горы

4. Море и горы

5. Море и горы

6. Море и горы

7. Море и горы

8. Море и горы

9. Море и горы

10. Море и горы


11. Море и горы

12. Море и горы

Суралцагчдын ном уншсаны дараах сэтгэгдэл өндөр, баярласан сэтгэл илэрхий байгаагаас нь санаа авч номыг орчуулсан Х.Хулан, редактор Ж.Дашдондог гуай нарт талархсан сэтгэлээ илэрхийлэх захидал бичихийг санал болгоход бараг бүгдээрээ орчуулагчид захидал бичсэн байлаа.

[illegible]

Хоёрдугаар улиралд төлөвлөлтийн дагуу төрийн шагналт зохиолч П.Хорлоо гуайн “Хоньчин Хумбаадай” үлгэр туужийг сонгож тайлангаа тавьсан.



	Нэгдүгээр бүлэг I. Баясахын талын наадам II. Эвт дөрвөн амьтан
	Хоёрдугаар бүлэг Өлзийт найман тэмдэг
	Гуравдугаар бүлэг Үнэт есөн эрдэнэ
	Дөрөвдүгээр бүлэг Ивгээлт 12 жил
	Тавдугаар бүлэг Хүслэнт дөрвөн бэрх

Зохиогч “Ард олны энх амгалан, аз жаргал, хүсэл мөрөөдлийн бэлгэдэл зөгнөлийн оюун санааг тусгасан ардын билэг зүй”-г хүүхдэд танилцуулах зорилгоор энэхүү үлгэрийн 33 холбоог хэлхсэн бол багш би ардынхаа уламжлалт зан үйлийг суралцагчдадаа таниулах, тэднийг чадваржуулах хэрэглэгдэхүүн болгон үйл ажиллагаандаа ашиглалаа.

Үлгэрийн нэгдүгээр бүлэг болох “Баясахын талын наадам”, “Эвт дөрвөн амьтан”-г ангидаа уншиж дүрд тоглосон бол хоёрдугаар бүлгийн “Өлзийт найман тэмдэг”-ийг бие даан уншиж зургийг нь будаж, ангидаа байрлуулсан.

Гурав, дөрөв, тавдугаар бүлгийг хүүхэд нэг бүрийн оролцоог хангах, тэднийг тэгш хөгжих боломжоор хангах үүднээс “Үнэт есөн эрдэнэ”, “Ивгээлт арван хоёр жил”, “Хүслэнт дөрвөн бэрх” багт хувааж бусдад ойлгомжтойгоор уран тод ярих, дүрд тоглох даалгавар өгч, үүгээрээ чанартай, үр дүнтэй тайлан тавьсан болно. /9+12+4=25 сурагч/

Гуравдугаар улиралд “Ухаан далай номоос эхтэй -1, 2” сонгож уншуулсан бөгөөд “Монголын нууц товчоо”, Д.Гармаа “Аав цэцрлэгт орсон нь”-оос гадна зохиолчийн санааг илэрхийлэн уран унших зорилгоор шүлэг сонгон чээжиллээ.

“Монголын нууц товчоо”-ны хялбаршуулсан хэсгүүдийг унших явцад зурагтаар “Чингис” кино гарч байсан нь харьцуулан ярилцах боломжтой байсан. Мөн ангидаа танин мэдэхүйн асуулт, хариулт бүхий хөлөгт тоглоомыг багаараа тоглож байна.



12. Акуут: Тайбулд баригдах Тайбул орноос хэн тусалдаг бэ? Акуут: Сүхэйсийн Сэрэн илр унтайт муушги тэргэлтэ мууш Тайбулдас тусал. 13. Акуут: Тэмгийн найман ширэ мороо алаад муунгинаа хаахад хэмий хэн хаа тусалд? Акуут: Налуу баян ганц хүү Боорин алаад найман ширэ мөрйг буцаа хаахд тусал. 14. Акуут: Тэмгийн Биш хан Тоортойрчи хүүг үз болохдоо юу асуудаг бэ? Акуут: Бурхууд ганц	15. Акуут: Мүргэдүгэс Бэртү ахгүй буцаа амалса хэн тусалдаг бэ? Акуут: Хэрфийнэ Тоорц ван, Хаахын оогийн Жааууа хуучин 16. Акуут: Мөрхийнэ турши ахынгаа хамгийн үүрмээр юу болдог Уяаг Мүргэдүнэ тэргүүний эр хэн бэ? Акуут: Тоготги байх 17. Акуут: Жаауууа хүү Тайвор мууш ууруу амаа алдаа? Акуут: Жин-Дараагийн ахууд дархмалын уугуу нуруугаа хута ахруулан алалда. 18. Акуут: Чингис, Жааууа нэр хаана байхдаг бэ? Акуут: Тал-Далаабаахуугааг хамгай байлдаг, Чингис Жааууаа хаахад Оноо мөрний Тэргэн хаанад нурчин эрх олох бэ? 19. Акуут: Чингис хааны хүүтүг мархуудууд Зүшэй ахисноор юу хэн бэ? Акуут: Зураагай 20. Акуут: Огдун хэн хэн хэнийн "Өдөр үлд нэвсэн сонсох чин бөлгөө" гэж хэлсн бэ? Акуут: Огродон дорон хүү, Мөрхийнэ нутгас олоон Хүү	Тайбулд бусд нутгас олоон Хаауу нутгууд Татарын нутгас олоон Шинэнуту Күршийн нутгас олоон Бөрүүнү 21. Акуут: Таварболтуургаа уугуу уураа, уруулаа нэр барис ахисноор болонхуу тэд хатууын өмнөх оноо хувисийн адал батуу жаахад болон бөгөөт гэж хэн үр үзүлээд орчин хүмүүтүлдэл байлсаг бэ? Акуут: Огдун хэн 22. Акуут: Чингис хаа хэмийн "Чингис турши яаах чин үүр" хэмийн
32. Акуут: Бурхууд катар нутгай барис байла Харуу болон хуучнаа халаа болон Хаан ил мөнх хатууаг орноо гэж хэн хмд хэлсэ. Акуут: Жааууа Чингис хаан. 33. Акуут: Бүр улаан доронх хуучнай өвөрүлжэ Хуучна мөнгөн уургууд бөлөг уургууд Яаах хэмдээ алдаа бэ гэж хэмийн бүр улаан эргэн болсон бэ? Акуут: Таларын нутгас олоон хүү Шинэнуту улаан эргэн болсон.	34. Акуут: Чингис хаа өрөө сүхтүлүүсүн хэн ноёрыг сонс улаа дорон хаахууд гэж хэн хамга болсон бэ? Акуут: Зэмэл, Бөрүтэ 35. Акуут: Чингис хаа уураа хүүрүүний галаад мүнхнэ ноёдоос оноо хэмийн уургууд бэ? Акуут: Шинэнуту 36. Акуут: Чингис хааны дорон хэн мөхөт буюу хэн сайт хэн хэн бэ? Акуут: Бөрүтэ, Боорин, Мүргэдүн, Чүзүн 37. Акуут: Чингис хааны дархмал хэрхэ. Акуут: Бөрүтэ, Зэмэл, Боорин, Сэрэн нэр 38. Чингис хааны дорон ноёос буюу хатгалсаа иргэд. Акуут: Хүбүний, Зэмэл, Звн, Сүбүний 39. Акуут: "Өзөө хэлсэндэ улаш олжаах Улаш хэлсэндэ оёлоо яваах адал батуу бөгөөт бүү үү? Ураг хэлсэндэ катару бөгөөт адал батуу үү" гэж Чингис хаа хмд хэлсэ? Акуут: Мянган хэн	40. Акуут: Чингис хааны ууган хувтуйн нэр хэн бэ? Акуут: Зууг 41. Акуут: Чингис хаа умар түрүүн 11-н хар аяах ухал адал батриу болсон бэ? Акуут: Сүбүний жаахчин 42. Акуут: Чингис хаан Алтай уураа дүүр хамт онд уур урмас хэлсн болсон бэ? Акуут: Жүбийн болон түтүүн ойно уураа Хятадын Алтай хаан ахисноор уураа 1214 онд Чингис хаан адал байлсаах мөрөөс.

Шүлгийн үг, мөр, шад, бадаг бүрийн утгыг ойлгож, гол санааг ухаарснаар уран уншихын тулд зохиолчийн баярласан, бахархсан, омогшсон эсвэл уйтгарласан, гунигласан сэтгэл хөдлөлийг мэдэрч унших нь чухал. Ингэвэл биеийн хөдөлгөөн, дууны өнгө аяс, нүүрний хувирал аяндаа илэрдэг байна.



3. ДҮГНЭЛТ


3.1. Онцлог, ач холбогдол

Хичээлээс гадуурх үйл ажиллагааны энэ цагаар сурах явцын үндсэн суурь унших чадварыг хүүхэд нэг бүрийн оролцоонд тулгуурлаж, тэднийг тэгш хөгжих боломжоор хангах арга зүй, алхмаар хэрхэн хөгжүүлж болохыг тусгаснаараа онцлог.

Багш миний хувьд “Ангийн номын сан”-гийн төсөл хэрэгжсэнээс хойших 8 жилд үе үеийн 5-р ангийн сурагчдын төдийлөн сонгож уншаагүй номуудыг яаж уншуулах вэ? гэдэг арга зүйтэй болсон. Үүнд;

- Сонгож уншихгүй байгаа номыг ажиглалтын явцад илрүүлэх
- Уншихгүй байгаа номыг нь унших сэдлийг нь төрүүлэх /эхлэл хэсгийг нь сонирхолтой хэлбэрээр уншиж өгсөн, уншсан хүүхдээр яриулах гэх мэт/
- Бие даан болон хамтаараа унших эсэхээс нь шалтгаалж номын агуулгад нь тохирсон, тухайн цаг үед бусад судлагдахуунаар эзэмшиж буй чадваруудтай нь холбоотой даалгавар өгөх
- Даалгаврын биелэлтээр нь тайлан тавиулж, бусдаас суралцах боломж олгох

Суралцагчдын хувьд номыг бүтээлчээр уншсаны үр дүн нь монгол хэлний судлагдахуунаар эзэмших ерөнхий ба тусгай чадваруудаар шууд илэрч байна.



Дээрх графикт энэ хичээлийн жилд монгол хэлний судлагдахуунаар эзэмших 15 ерөнхий чадвараар нэрлэгдсэн нэгж хичээлийн явцын үнэлгээг харуулав. Үүнээс харахад “Үзэл бодлоо илэрхийлэн бичиж суръя” /захидал бичих/, “Зохиолоос үнэлж дүгнэх асуулт асууж сурцгаая”, “Илтгэх чадварт суралцъя”, “Зохиолын учир

шалтгааныг дүгнэн ярьж бичигчээ”, “Нэг сэдэвтэй хоёр эхийг харьцуулъя” /зар сурталчилгаа/, “Далд утгыг таамаглаж тайлбарлая” /оньсого/, “Зохиолчийн санааг илэрхийлэн уран уншъя”, “Эхийн орчныг төсөөлөн бодож өөрчлөн бичье”, “Хэлэлцүүлэг хийж сурцгаая”, “Уран сэтгэмжээ хөгжүүлье”, “Дүрээр илэрхийлэх чадвараа хөгжүүлье” гэсэн 11 нэгж хичэлийн явцын үнэлгээнд 85 – 100% буюу “Онц” гэсэн үнэлгээгээр ангийн нийт сурагчдын 50 буюу түүнээс дээш хувь нь үнэлэгджээ.

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй түүхэн цаг үед энэ үйл ажиллагааг хэрэгжүүлснээр суралцагчдын дараах чадварууд хөгжлөө. Үүнд:

- Бие даан ном унших сонирхол нь илүү нэмэгдсэн.
- Яриагаа төлөвлөх, бэлтгэх, бусдын дэмжлэггүйгээр илэрхийлж чаддаг болсон.
- Зохиолын үгээр товч тодорхой, уран яруу, оновчтой ярих чадвар нь сайжирсан.
- Бусдыг яриаг сонирхон сонсох нь илүү болсон.
- Агуулгыг дүрээр болон зургаар бүтээлчээр сэтгэн илэрхийлэх чадвар дээшилсэн.
- Баатруудын хорондын холбоо, сэтгэл санааны өөрчлөлтийг дүрсэлж дүгнэлт хийдэг болсон.
- Үзэл бодлоо баталгаа нотолгоотойгоор илэрхийлж байна.

3.2. Анхаарал татсан асуудал, бэрхшээл

Дөрөвдүгээр улирлаас эхлэн манай аймгийн хувьд хичээлээс гадуурх үйл ажиллагааны мөн чанарыг буруу ойлгосон байна. Энэ үйл ажиллагаа бол ном уншдаг, шүлэг чээжилдэг цаг биш гэгдийг БШУЯ-ны хэрэгжилтийн багийн хамт олны сургалтаас ойлгосноор номоо бүтээлчээр унших тогтсон цаггүй болсон.

3.3. Шийдвэрлэсэн байдал

Анги бүр 7 хоногийн нэг өдрийн тодорхой цагт суруулийн номын санд ном уншдаг хуваарьтай. Энэ хуваарь дээр номын санчтайгаа зөвшилцөн дөрөвдүгээр улиралд уншихаар сонгосон “Өөрийгөө танин мэдэх, эрүүл мэндээ хамгаалах” чиглэлийн номоо уншиж байна.

4. ДЭВШҮҮЛЭХ САНАЛ

4.1. Бусдад хүргэх санал

Нэг үе хүүхэд ном уншихаа больж, бэлтгэгдсэн боловсон хүчний ихэнх нь алдаатай бичдэг болсныг боловсролын салбарын бодлого, багш нарын арга зүйтэй холбон нэлээдгүй шүүмжилсэн.

Хөдөөгийн боловсролыг дэмжих “READ” төсөл хэрэгжсэнээр хүүхэд сургуульд оронгуутаа унших номтой болсон, мөн “Эрдэм боловсролтой монгол хүн” чиглэлийн хүрээнд “Ном” хөтөлбөр амжилттай хэрэгжсэн. Эдгээрийн үр дүнг үргэлжлүүлэн хүүхэд нэг бүрийг номтой нөхөрлүүлэе, багш бид ч номыг бүтээлчээр уншуулах арга зүйгээ тасралтгүй хөгжүүлэе.

“Хүн болох багаасаа

Хүлэг болох унаганаасаа”

“Шавийн эрдэм багшаасаа

Зулын гэрэл тосноосоо” гэдэг шүү дээ.

4.2. Цаашид хөгжүүлэх санаа

- Ном унших цаг 7 хоног 1 цаг байхаар сургалтын төлөвлөгөөнд тусгах.
- Сургууль бүр дээр “**Уянгад нь нэвтэрвэл бүхний гайхамшиг**” хөгжүүлэх дугуйланг авьяаслаг багш нараар хичээллүүлэх
- Бүтээлчээр ном сайн уншдаг суралцагчдыг алдаршуулах үйл ажиллагааг үндэсний хэмээнд зохион байгуулах

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3-р сургуулийн
бага ангийн багш Лхагва овогтой Цолмон

L.Tsolmon_1018@yahoo.com

Утас: 99020523, 99030513

